



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 10 сарын 27 өдөр

Дугаар А/339

Улаанбаатар хот

「Хан-Уул дүүргийн 67 дугаар цэцэрлэгийн
эргэлтийн бус хөрөнгө данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 11,516,000 (арван нэгэн сая таван зуун арван зургаан мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Хан-Уул дүүргийн 67 дугаар цэцэрлэг (С.Мөнхцэцэг)-т зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 4 нэр төрлийн 11,516,000 (арван нэгэн сая таван зуун арван зургаан мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 108,000 (нэг зуун найман мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 32,400 (гучин хоёр мянга дөрвөн зуу) төгрөгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газрын төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Хан-Уул дүүргийн 67 дугаар цэцэрлэг (С.Мөнхцэцэг)-т, орлого төвлөрүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс (М.Мандах)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050000951

